



# Монголын Ардчилсан Хөдөлгөөний Нам “МОНАРХН”

2008 оны 05 сарын 14-йдээр

№ 44

Улаанбаатар хот

## Бүгд хурлын тогтоол

**2008 оны УИХ-ЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ТУХАЙ**

МОНАРХН-ЫН БҮГД ХУРЛААС ТОГТООХ НЬ:

1. 2008 оны УИХ-ЫН СОНГУУЛЬД Монголын Ардчилсан Хөдөлгөөний Нам дэлгэрээс оролцох тогтох, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг баталсугай.

2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу Монголын Ардчилсан Хөдөлгөөний Намын сонгуульд оролцох эрхийг баталгаажуулах, СЕХ-нд Намыг болон намаас нэр дэвшигчдийг бүртгүүлэх ажиллагааг сонгуулийн Ерөнхий менежер Т.Оюунаад даалгасугай.

3. Монголын Ардчилсан Хөдөлгөөний Намын УИХ-ЫН СОНГУУЛИЙН Импранит ажлыг удирдан зохион байгуулах эрхийг Сонгуулийн төв штабтайгасугай.

4. Гишүүдийн саналд үндэслэн, Бүгд хурлаар хэлэлцэгдсэн, УИХ-ЫН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧДИЙГ ХАВСРАЛТААР БАТАЛСУГАЙ.



**Намын дарга:**

МОНГОЛЫН  
АРДЧИЛСАН  
ХӨДӨЛГӨӨНИЙ  
НАМ  
Ерөнхий нарийн бичгийн дарга:  
УХ33055

/Т.Оюунаа/

.....  
  
/М.Ганзориг/



## Монголын Ардчилсан Хөдөлгөөний Намын Сонгуулийн мөрийн хөтөлбөр

**Монгол Улсын ардчиллын ууган байгууллага МоАХ-ны анхдагчдын үүсгэл санаачлагаар байгуулагдсан – Монголын Ардчилсан Хөдөлгөөний Нам нь:**

18 жилийн тэртээ Монголын нийгмийг үндсээр нь өөрчилж, ардчиллыг тунхагласан боловч эх орныхоо өнөөгийн байдалд дүн шинжлэл хийж үзээд, төрийн шинэчлэлийн бодлогыг дэвшүүлэн хэрэгжүүлэх нь зүйтэй юм гэж үзлээ. Энэ бол зөвхөн бидний эрмэлзэл биш, Монголын нийт ард түмний хүсэл зориг мөн болохыг нийгмийн өнөөгийн байдал тодорхой харуулж байна. Тиймээс 18 жилийн тэртээ Монгол улс, Монголын төр, Монголын нийгмийг хөтлөх ёстой байсан ардчилал, шударга ёс, тусгаар тогтолцоо дээдэлсэн тэр л замыг бид дахин сонгож, сонгуулийн мөрийн хөтөлбөрөө баталсан юм.

**МАНАЙ УРИА: Нам төвтэй төрийг халж,  
Монгол хүнээ дээдэлсэн төрийн төлөө!!!**

### 1. Түмнээсээ асууж - Төрөө цэгцлэе! (Төрийн бодлогын шинэчлэл)

- Монгол хүн бол Монгол төрийн үндсэн баялаг мөн болохыг Үндсэн хуулиараа баталгаажуулж, Монгол хүнийг дээдэлсэн, монгол соёл ахуй, зан заншил дээр тулгуурласан үзэл баримтлалыг Үндсэн хуулиараа баталгаажуулна.

-Монгол түмнийг яс үндэс, шашин шүтлэг, нам бүлэг, жалга довны үзлээр хагалан бутаргаж буй явдлыг таслан зогсоож, энэ илрэлтэй төрийн бодлогоор, хуулийн хүрээнд эрс шийдэмгий тэмцэнэ.

-Ард түмэнгүй төр, төргүй ард түмэн гэж үгүй тул ард түмэндээ бүрэн үйлчлэх, хяналттай, ил тод байх зарчмыг төрд нэвтрүүлнэ.

-Төрийн үндсэн баялаг болох Монгол хүний өсөлт, хөгжил, амьдралын баталгааг хангах хүн ам зүйн бодлогын хүрээнд хүн амын бүртгэлийн боловсронгуй, нэгдсэн системийг бий болгож, Монгол хүний өмчлөх, эзэмших эрхийг баталгаажуулах, гэмт халдлагаас сэргийлэхийн тулд хөрөнгийн бүртгэл мэдээллийн төвлөрсөн сан байгуулна.

- “Хариуцлагатай төр - хяналттай парламент - чадварлаг Засгийн газар” гэсэн тэнцвэрт харьцааг төлөвшүүлнэ.

-Бүх ард нийтийн санал асуултыг явуулж, Үндсэн хуулиа шинэчлэн, төрийн тогтолцоог боловсронгуй болгоно.

-Нам төвтэй төрийг халж, Монгол хүнийг, иргэнээ дээдэлсэн, Монгол хүний хөгжил болон иргэний санал санаачлага дээр тулгуурласан төртэй болно.

-Төрийн чиг үүргийн төвлөрлийг сааруулж, иргэд, иргэний байгууллагуудын болон хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлнэ.

-Төрийн бүх шатны байгууллагуудын үйл ажиллагаа болон төсвийн зарцуулалтанд хөндлөнгийн хяналт тавих эрх бүхий Олон нийтийн хяналтын зөвлөлийг иргэний байгууллагууд, иргэдийн оролцоотойгоор байгуулж ажиллуулна.

-Төрийн албаны бүх шатанд авлига, хүнд суртал, шударга бус байдлыг халж, төрийн байгууллагуудын мэдээлэл, ажил, үйлчилгээг ил тод, шударга, шуурхай болгохын тулд онлайн үйлчилгээний хэлбэрийг өргөнөөр нэвтрүүлнэ.

-Төрийн албан хаагчийг сонгон шалгаруулдаг системийг боловсронгуй болгож, онлайн хэлбэрт шилжүүлсэнээр шударгаар өрсөлдөж, эрдэм боловсролтой, ур чадвартай, эх оронч иргэдэд хөрөнгө мөнгө, танил тал харгалзалгүй төрийн албанд орох боловмжийг бий болгоно.

-Эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгож, Монгол хүнийг дээдэлсэн, монголчуудын түүх соёл, уламжлалд тулгуурласан, шинжлэх ухааны үндэслэлтэй, чанартай, үйлчлэх чадвартай хууль тогтоомжуудыг гаргаж, хуулийн хэрэгжилтийг хангахуйц шинэчлэл хийнэ.

-Нийгмийн хөгжлийг тодорхойлогч хууль, эрх зүйн актуудыг ард түмнээрээ заавал хэлэлцүүлж, санал бодлыг нь тусгадаг болгон хэвшүүлнэ.

-Улс төрийн намууд болон бизнес-улс төрийн бүлэглэлүүдэд бус, сонгогч иргэдэдээ үйлчилдэг, жинхэнэ ардчилсан, шударга сонгуулийн тогтолцоог бий болгоно.

-Ардчиллын үндсэн зарчмуудын нэг болох иргэн бүр хуулийн өмнө адил тэгш байх зарчмыг нийгэмд хэвшүүлэн хэрэгжүүлнэ.

-Шүүх засаглалын хараат бус, шударга, ардчилсан байх зарчмыг хэрэгжүүлэх орчин нөхцлийг бүрдүүлнэ.

- **Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын тулгуур багана болсон төрийн хүн ам зүйн бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ.**

-Үндэсний аюулгүй байдлыг хангах үзэл баримтлалыг хүн ам зүйн бодлоготой уялдуулж, тусгаар тогнолынхоо баталгааг хангана.

-Үндэсний аюулгүй байдлыг хангах, тусгаар тогтнолоо хамгаалах үйлст эх оронч, үндэсний үзэл дээр тулгуурласан, иргэдийн сайн дурын оролцоо, идэвхи санаачлагыг нэмэгдүүлэх хөшүүргийг бий болгоно.

-“Монгол хүний хөгжил – Улс орны хөгжил – Тусгаар тогтнолын баталгаа” үзэл баримтлалыг иргэн бурт төлөвшүүлэхэд анхаарч, хуульчлан тунхаглана.

-Үндэсний аюулгүй байдлаа хангаж, тусгаар тогтнолоо бэхжүүлэх үүднээс гадаад орнуудтай нээлттэй, харилцан шударга, эрх тэгш харилцах бодлого баримтална.

-Үндэсний аюулгүй байдал, Монгол түмний эрх ашгийг бусад аль ч улс орны улс төр, эдийн загсийн ашиг сонирхлоос эгнэгт дээгүүр тавих бодлогыг хуульчлан хэрэгжүүлнэ.

-Гадаад орнуудад ажиллаж амьдарч буй Монгол иргэд нь Монголын төрийн үндсэн баялаг мөн болохоор үндэсний аюулгүй байдал, тусгаар тогнолын нэгээхэн хэсэг хэмээн үзэж, эрх ашгийг нь төрийн бодлогоор тууштай хамгаална.

## **2. Төвлөрсөн эдийн засгаас – Олон хэвшилт эдийн засаг руу! (Эдийн засгийн бодлогын шинэчлэл)**

- **Монополийн буюу ченжийн эдийн засгийг төрийн зохицуулалтаар халж, чөлөөт өрсөлдөөний зах зээлийг жинхэнэ утгаар нь бий болгоно.**

-Төрийн мөнгөний бодлогыг үндсээр нь өөрчилж, бодит бүтээгдэхүүнээр баталгаажсан үндэсний валюттай болсоноор инфляцийг бууруулж, улс орны эдийн засгийг тогтворжуулна.

-Эдийн засаг дахь төрийн оролцоог багасгаж, хувийн хэвшлийг төрийн бодлогоор дэмжиж хөгжүүлнэ.



-Монгол хүнийг хөгжүүлж, оюуны хоосрол, ядуурлаас бүрэн гаргаж, үндэсний баялаг үйлдвэрлэгч болох эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.  
-Өрх бүр үйлдвэрлэгч, иргэн бүр эзэн байх боломжийг төрийн эдийн засгийн бодлогын шинэчлэлээр олгоно.

-Цөөн тооны томоохон орд газрыг төрийн эдийн засгийн бодлогоор, эргэн нөхөгдөх нөхцөлөөр эргэлтэнд оруулж, байгаль орчин, хүн амын эрүүл оршихуйд халгаатай жижиг, дунд уурхайнуудыг хаана.

- **Өмч хувьчлалыг шалгах олон нийтийи хяналтын бүтцийг бий болгосноор өмч хувьчлалын булхайг илчилж, хохирсон иргэдийнхээ эрхийг эдийн засгийн аргаар хамгаална.**

-Төрийн хөрөнгөөр бүтээн байгуулагдсан бүх объектын хувьчлалыг арган хянаж, дахин хуваарилалт хийх замаар Монгол айл өрх бүрийг бодит өмчтэй болгож, амьжиргааны эдийн засгийн баталгааг хангана.

### **3. Боловсролтой Монгол хүн – Хөгжлийн Монгол орон! (Хүний хөгжлийн бодлогын шинэчлэл)**

- **Төрийн баялаг болсон Монгол хүнийг хөгжүүлэх нь улс орны хөгжлийн үндсэн баталгаа мөн гэдгийг хуульчлан, төрийн бодлогоор боловсруулж хэрэгжүүлнэ.**

-Монгол түмний үр удмаа дээдлэх уламжлалт зан заншил, соёл ахуй дээр тулгуурласан бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулж, монгол хүний эхийн хэвлийд бүрэлдэхээс нь эхлүүлээд төрийн бодлогоор хүнээ хalamжлан хүмүүжүүлнэ.

-Монгол хүний хөгжлийг хангах үндсэн хүчин зүйл болсон боловсролын салбарын бодлогыг үндсээр нь шинэчилж, үндэсний онцлог, зан заншилд тулгуурласан, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

-Монгол хүнийг хөгжүүлэх гол хүчин зүйл болсон боловсролын салбарыг төрөөс онцгойлон анхаарч, эдийн засгийн хөшүүргээр дэмжинэ.

-0-18 насны иргэдийн боловсролын зардлыг төр бүрэн хариуцаж, бодлогоор иргэдэдээ хөрөнгө оруулалт хийнэ.

-Авьяаслаг, хичээнгүй залуусыг төрийн зардлаар гадаад, дотоодын тэргүүлэгч их, дээд сургуулиудад сургах, төгсгөөд эх орны үнэт боловсон хүчин болгож, ажлын байраар хангах явдлыг төрийн бодлогын түвшинд хэрэгжүүлнэ.

-Дэлхийн жишиг стандартад ницсэн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд, мэргэжлийн чиг баримжаа олгох, хос мэргэжлийн сургуулиудыг байгуулж, суралцаасдыг төрийн бодлогоор дэмжиж, ажлын байраар хангана.

-Тусгай болон дээд боловсрол эзэмшихээр суралцаж, сурлага, авьяас чадвараараа тэргүүлэгч, эх орондоо хэрэгтэй санаачлага гаргасан оюутнуудыг төрийн бодлогоор дэмжинэ.

- **Соёл урлаг, шинжлэх ухааныг Монгол хүнийг хөгжүүлэх нэгэн хөшүүрэг болгоно.**

-Монгол хүнийг эх оронч үзлээр хүмүүжүүлэхийн тулд үндэсний түүх, соёл урлагийг төрийн бодлогоор дэмжинэ.

-Дэлхий дахинд тэргүүлж буй шинжлэх ухаан, технологийн чиглэлүүдийг эх орондоо нэвтрүүлэн хөгжүүлэхэд онцгой анхаарч, шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлээр нарийн мэргэшсэн эрдэм шинжилгээний ажилтан, судлаачдыг бэлтгэх, сургах, мэргэшүүлэх тусгай хөтөлбөр гаргаж, төрийн бодлогоор дэмжинэ.

-Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх, хөгжил дэвшилд тулгуурласан баялаг бүтээгч салбарыг үүсгэн бэхжүүлэхэд төрөөс үзүүлэх эдийн засгийн дэмжлэгийг нэмэгдүүлнэ.

#### 4. Эрүүл байгаль – Эрүүл Монгол хүн (Байгаль - Экологийн бодлогын шинэчлэл)

- Байгаль – экологийн аюулгүй байдлыг хангахад иргэн бүрийн оролцоог төрөөс хөхиүлэн дэмжиж, Монгол хүний эрүүл орчинд амьдрах Үндсэн хуулиар баталгаажсан эрхийг төрийн бодлогын түвшинд хангана.

-Байгаль – Экологийн тэнцвэрийг алдагдуулж, Монгол хүний амьдрах орчныг бохирдуулан, Үндэсний аюулгүй байдалд заналхийлж буй аливаа илрэл, үйл ажиллагаатай эрс шийдэмгий тэмцэж, таслан зогсоох, хариуцлага тооцох, нөхөн сэргээх, хор хохирлыг арилгах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

-Эх оронч иргэдийн санал санаачлагыг төрийн бодлогоор хөхиүлэн дэмжиж, хяналтыг чангатгаснаар аливаа хор хохирол, гамшигийг гаргахаас өмнө нь сэргийлж хэвшүүлэхэд анхаарна.

-Монгол түмний уламжлалыг дээдлэж, эх болсон байгалиа сүйтгэн, газар шороогоо сэндийчин сүйтгэж буй уул уурхайн салбарын үйл ажиллагааг төрийн бодлогоор цэгцлэн хумина.

-Монгол орны байгалийн баялгийн ашиглалтад хатуу хараа хяналт тогтоож, эх нутгаа цөлмөн хоосолсон, хордуулж бохирдуулсан, байгалийн тэнцвэрийг алдагдуулсан иргэд, байгууллагуудтай хатуу хариуцлага тооцож, нэгэнт сүйтгэгдээд буй газар орны нөхөн сэргээлтийг албадан хийлгүүлэхэд анхаарч ажиллана.

-Байгалийн ямар ч баялгийг түүхийгээр нь буюу боловсруулалгүй гадаад оронд гаргахыг хуулиар хориглуулж, эх орныхоо баялаг, байгаль орчныг хамгаална.

#### 4. Хөдөлмөр – Хөгжлийн үндэс! (Улс орны хөгжлийн бодлогын шинэчлэл)

- Монгол хүн болгоныг эх орны баялгийг бүтээгч, Монгол орны хөгжлийг хурдаасгагч болгохын тулд амьдралын баталгааг нь бүрэн хангах, шударгаар хөдөлмөрлөх нөхцөлийг төрийн бодлогоор бий болгоно.

-Төрийн үндсэн баялаг болсон Монгол хүн амьдралдаа хүрэлцэхүйц хэмжээний цалин хөлстэй, хөдөлмөрлөх эрүүл тухлаг орчинтой ажлын байраар хангагдахад анхаарч, төрийн бодлогоор зохицуулна.

-Монгол хүн бүрийн эх оронч үзэл болон төрийн эдийн засгийн бодлого дээр тулгуурлан үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.

-Ажлын байр нэмэгдүүлэх дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулж, олон улсын жишигт нийцүүлнэ.

-Төрийн хяналт, оролцоотойгоор цөөн тооны стратегийн орд газруудыг ашиглаж, ашгийн дийлэнх хэсгийг улс орны хөгжлийн томоохон хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хэлбэрээр, байнга өсөн нэмэгдэж байх нөхцөлөөр оруулахын төлөө ажиллана.

-Орд газруудаас олсон ашгийн тодорхой хэсгийг Монгол хүн бүрт бэлэн мөнгө хэлбэрээр бус, харин тодорхой хөрөнгө оруулалт маягаар хишиг хүртээж, амьдралын баталгааг нь хангана.

-Монгол улсын нэрийн өмнөөс бүтээгдэхүүнээ олон улсын зах зээл дээр гарган нийлүүлдэг үндэсний үйлдвэрүүд, компаниудыг төрийн бодлогоор дэмжинэ.



-Хүнсний аюулгүй байдлыг хангахын тулд энэ чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг үндэсний компаниудад хатуу хяналт тогтоож, чанарын шаардлага хангасныг нь төрийн бодлогоор хөхиулэн дэмжинэ.

-Бүс нутгуудад Үндэсний үйлдвэрлэл-технологийн паркуудыг төрийн өмчийн оролцоотойгоор байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлж, дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлнэ.

-Үндэсний компаниуд, жижиг, дунд үйлдвэрүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд төрөөс бүх талын дэмжлэг үзүүлнэ.

-Аялал жуулчлалын салбарыг улс орны хөгжлийн тэргүүлэгч салбаруудын нэг болгоход анхаарч, төрийн бодлогоор дэмжинэ.

- **Шинжлэх ухааны ололт дээр сууринсан, хөгжингүй технологийн салбарыг улс орныг хөгжүүлэгч тэргүүлэгч салбар болгоно.**

-Одоо ашиглагдаж буй зарим томоохон орд газруудын ашиглалтыг сайжруулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник технологийг шинэчлэх, байгаль орчинд хоргүй технологи нэвтрүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.

-Одоо олгогдчихоод байгаа ашигт малтмалын лицензүүдийг хянан шийдвэрлэнэ.

- **Мал аж ахуй, газар тариаланг төрийн зохистой бодлогоор дэмжин хөгжүүлж, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах хэмжээнд хүргэнэ.**
- **Дэд бүтцийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулж, салбар хоорондын уялдааг ханган, 2012 он гэхэд Монгол Улсын зам тээвэр, харилцаа холбоо, түлш эрчим хүч, барилга байгууламжийн хүртээмжийг хүн амын өсөлттэй уялдуулан бүрэн шийдвэрлэнэ.**

-Түлш, нөfty бүтээгдэхүүн, эрчим хүчээр дотоодынхоо хэрэгцээг бүрэн хангах чиглэгдсэн төрийн бодлого боловсруулж, дэс дараатай хэрэгжүүлнэ.

## **5.Хүнлэг, ардчилсан нийгмийн төлөө! (Нийгмийн бодлогын шинэчлэл)**

- **Ашигт малтмалын салбараас олох орлогыг бэлнээр тараах бус, эрүүл мэнд, соёл боловсрол, спорт, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, нийгмийн халамжийн салбарт хөрөнгө оруулалт хэлбэрээр ашиглана.**

-Төрөөс үзүүлж буй нийгмийн хамгаалал, халамжийн бодлогыг шинэчилж, нийгмийн хамгааллын үйлчилгээг хүнд сурталгүй, шуурхай болгож, онлайн хяналтын системийг байгуулж, иргэдийн санал гомдлын дагуу шуурхай арга хэмжээ авдаг системийг бий болгоно.

-Нийгмийн баялгийг бүтээлцсэн ахмад настнуудын тэтгэвэр, тэтгэмжийн доод хэмжээг 300 мянган төгрөгт хүргэнэ.

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохируулсан ажлын байрыг төрийн бодлогоор бий болгож, амьдралын баталгаагаар хангана.

-Ажилгүй иргэд, нийгмийн эмзэг давхаргынхныг ажлын байраар хангах, амьдралын баталгааг бүрдүүлж хангахад төрийн бодлогоор анхаарна.

- **Төрийн үндсэн баялаг болох хүн амын өсөлтийг хангах зорилгоор гуравдахь хүүхдээ төрүүлсэн эхэд төрийн албан хаагчийн цалинтай адилтгахуйц хэмжээний цалинг хүүхдийг нь насанд хүртэл олгоно.**

-Дөрөвдэх хүүхдээс эхлээд шинээр мэндэлсэн хүүхэд болгоны төлөө эхэд цалинг олгоно (ажил хөдөлмөр эрхэлдэг, эсэхээс үл хамааран).



-Тавдахь хүүхдээ төрүүлсэн эхийг төр орон сууцаар хангах, эсвэл түүнтэй адилтгах хэмжээний эдийн засгийн нэг удаагийн тэтгэлэг эдлүүлнэ.

-Хүүхэд болгоныг Монгол Улсын ирээдүй хэмээн үзэж, эрүүл саруул өсөх, хөгжиж боловсрохыг төрийн бодлогоор тэтгэнэ.

- Эрүүл мэндийн салбарт орчин үеийн шинжлэх ухаан, технологийн ололтуудыг нэвтрүүлж, бодлогыг шинэчилнэ.

-Монгол хүн нийгмийн гарал үүсэл, хөрөнгийн байдал, нас хүйс харгалзалахгүйгээр эмнэлгийн үйлчилгээ авдаг байх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

-Бус нутгуудын оношилгоо, эмчилгээний томоохон цогцолборуудыг гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, буцалтгүй тусламжаар барьж байгуулна.

-Эх наяхын эмчилгээ, оношилгооны орчин үеийн тоног төхөөрөмжтэй төвүүдийг байгуулна.

-Монгол хүн болгоныг эрүүл мэндийн даатгалд хамруулж, жилд нэг удаа урьдчилан сэргийлэх, цогц үзлэг, оношилгоонд үнэ төлбөргүй оруулж байх боломжийг төрөөс бүрдүүлнэ.

-Хүн амыг эрүүлжүүлэх бодлогыг спортоор хичээллэх, биээ чийрэгжүүлэх бодлоготой уялдуулж, "Эрүүл биед саруул ухаан" хөтөлбөрийг улс орны хэмжээнд хэрэгжүүлнэ.

-Монголчуудын уламжлалт анааах ухааныг сэргээх, орчин үеийн шинжлэх ухааны ололттой хоршуулан хөгжүүлэхийг төрийн бодлогоор дэмжинэ.

-Эмгүй эмчилгээний төвүүд, сэтгэл заслын төвүүд, стресс тайлах төвүүдийг байгуулах, хөгжүүлэх санал санаачлагыг төрийн бодлогоор хөхиүлэн дэмжинэ.

- Төрийн албан хаагчид, цагдаа хүчний байгууллагын ажилтнууд, цэрэг армийнхан, багш, эмч, эмнэлгийн ажилтнуудын цалин хангамжийг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг сайжруулна.

## 6. Эх орны зурх нь болсон нийслэл Улаанбаатараа хөгжүүлье! (Нийслэлийн бодлогын шинэчлэл)

- Хүн амын талаас илүү хувь нь төвлөрөх болсон нийслэл Улаанбаатар хотын бодлогыг үндсээр нь шинэчилнэ.

-Хотыг өргөжүүлэн тэлнэ.

-Эрчим хүчээр хангах өндөр хүчин чадал бүхий ТЭЦ-5 цахилгаан станцыг Налайх дүүрэгт байгуулсандаар нийслэлийг зүүн тийш нь тэлэн хөгжүүлнэ.

-Нийслэл хотын усан хангамжийг сайжруулах хүрээнд цэвэр усны шинэ, найдвартай эх үүсвэрийг хайж тогтооно.

-Улаанбаатар хотын Зүүн дэrvэн замаас Налайх хүртэл өндөр хурдны зам тавьж, ашиглалтанд оруулна.

-Нийслэл хотоос Их, дээд сургуулиуд болон соёл урлагийн зарим байгууллагуудыг Налайх дүүрэг рүү нүүлгэн шилжүүлнэ.

